



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН
ТУШААЛ

2025 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 4/03

Аварга

Ёс зүйн дэд хороо байгуулах тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33.3.1, 33.3.2 дахь заалт, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13.1, 13.2 дахь заалт, Монгол Улсын ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолын 2 дахь заалт, "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 3.8.5-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цэцэрлэгийн ёсзүйн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Үүнд: Ёс зүйн дэд хорооны дарга: Г.Улам-Өрнөх	-Хөгжмийн багш
Нарийн бичгийн дарга: Д.Алиманцэцэг	-Багшийн туслах
Гишүүн: Г.Энхчимэг	-Бүлгийн багш

2. Байгууллагын албан хаагчдад ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэх талаар жил бүр төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, үр дүнг тооцох "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэм"-ийг хэвшүүлэн ажиллаж, ёс зүйн дэд хорооны ажиллах журмын дагуу ажиллахыг ёс зүйн дэд хорооны дарга гишүүдэд даалгасугай.

3. Байгууллагын ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүн нарт журмын дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх урамшууллыг төсөвт багтаан олгохыг нягтлан бодогч (Д.Энхсаруул)-д зөвшөөрсүгэй.

ЭРХЛЭГЧИЙН ҮҮРГИЙГ

ХАВСРАН ГҮЙЦЭТГЭН

1824120070 9075958

С.ЭРДЭНЭСУВД